

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР**Санамж:**

1. Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг дуустал уншиж ойлгоорой.
3. 1-17 дугаар сорилыг эхийн утга санаатай холбож ажиллаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

*(Даалгавар бүр 2 оноотой)***ЭХ ОРОН**

Үр хүүхэд минь хар нялхаасаа эх орноо бие сэтгэлдээ тээж, сургууль, ээж, багш нараа, мөр зэрэгцэн суух бяцхан андаа бас сурах бичиг, суудаг ширээ сандал, ангийнхаа цонх, цонхоор харагдах улиас, улиасны мөчир бүхэн, мөчир дээр нь суух бяцхан болжморыг хүртэл Эх орон гэж ойлгосон цагт л бидний оюун санааны амьдрал эхлэх буюу.

Эртний их сүмийн туурь, энэ сүм хийдийг яагаад нураасан, хэрвээ алтан ганжир нь үүрийн туяа, өглөөний наранд гялалзаж, сүр жавхлантай 700 гаруй сүм хийд монгол нутаг даяар сүндэрлэж, мөргөл өргөлийн дуун эгшиглэж байсан бол... гэсэн бяцхан гуниг боргоцой жаахан үрсийн минь цээжийг эзэмдэж, төрөлх нутгийнх нь уулсад бугын дуу цуурайтаж ахуй цаг дор бид гоо сайхныг цээжний гүндээ мэдэрнэм.

Эх орон минь цаст Алтай, сүрлэг Хэнтий, униарт Хангай, шаргал говь, цэнхэр тал төдийгүй Чингис, Чингүнжав, Занабазар, Равжаа, Мянгат, Мандухай, Сүхбаатар хэмээх ойлголтоос бүрднэм. Монгол орныхоо төлөө харийн дайсантай тулалдсан Даваадорж, Тэгшээ нарын баатарлаг зориг, алаг морьтойгоо хүн ардын зүрх сэтгэлд мөнхөрсөн Дандар баатар, Норовбанзадын дуулсан уртын дууны уран нугалаа, өвлийн шөнөөр эмгэн ээжийн ярьсан үлгэр, бударсан цасан дундуур хөтлөлцөн алхах охид хөвгүүд цөм Эх орон юм. Итгэл алдрах бүрдээ би Монголын гайхамшигт баатруудыг санадаг юм. Тэднээс бэрхийг давах хүч тэнхээ авдаг.

Морио усалдаг булаг шанд, бутанд хярсан туулай, ялаа шумуул, цагаан дэрс, Явуухулангийн хайр, Чойномын хилэн, Цэрэндоржийн санаашрал, ээжийн минь мөргөл залбирал ч Эх орон юм. Эх орон минь зөвхөн газар шороо, гол мөрөн бус түүх домог, уй гашуу, ялалт, эмгэнэл билээ.

О. Дашбалбар

1. Үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- | | |
|---------------|--|
| 1. ганжир | a. уур бухимдал |
| 2. туурь | b. шашны сүм хийдийн орой дээрх чимэг |
| 3. хилэн | c. эртний сүм хийдийн үлдэгдэл |
| A. 1c, 2a, 3b | B. 1b, 2a, 3c C. 1a, 2b, 3c D. 1b, 2c, 3a E. 1c, 2b, 3a |

2. Цогцолборуудыг үйл үгээр зөв дараалуулсныг сонгоорой.

- A. эхлэх, мэдрэх, мөргөх, авах
- B. эхлэх, мэдрэх, санах, амьдрал
- C. эхлэх, мэдрэх, санах, мөргөх
- D. эхлэх, санах, мэдрэх, мөргөх
- E. цонх, улиас, мөчир, болжмор

3. Чингис, Мандухай, Занабазар, Сүхбаатар зэрэг түүхт хүмүүс аль цаг үед хамаатай вэ?

- | | | |
|--------------------------|--------------------------|--------------------------|
| A. 13, 16, 17, 18-р зуун | B. 13, 16, 17, 20-р зуун | C. 12, 13, 15, 19-р зуун |
| D. 12, 13, 14, 18-р зуун | E. 14, 17, 19, 20-р зуун | |



4. Эхийн сэдвийг түлхүүр үгсээр зөв тодорхойлсныг олоорой.
- A. ялаа шумуул, бяцхан болжмор, хярсан туулай, бугын дуу - ан амьтдын тухай
 - B. Сүхбаатар, Даваадорж, Тэгшээ, Дандар баатар - эр зоригийн тухай
 - C. сүм хийд, мөргөл залбирал, мөргөл өргөл, алтан ганжир - шашин шүтлэгийн тухай
 - D. булаг шанд, цагаан дэрс, улиасны мөчир, гол мөрөн - эх байгалийн тухай
 - E. үр хүүхэд, төрөлх нутаг, Монголын гайхамшиг, цөм - эх орны тухай
5. Эхийн сэдвээс гол санааг зөв дүгнэснийг сонгоорой.
- A. Бидэнтэй холбоотой бүхэн Эх орон юм.
 - B. Зөвхөн өвөг дээдэс эр зориг Эх орон юм.
 - C. Бидний орчинд буй зарим зүйл эх байгаль юм.
 - D. Эмгэн ээжийн ярьсан үлгэр л Эх орон юм.
 - E. Биднээс алсад байгаа зүйл ан амьтад юм.
6. “сүрлэг Хэнтий, Чингүнжав, Мянгат, улиасны мөчир, ялалт, эмгэнэл, ялаа шумуул...” зэргээр найруулсны учир юу вэ?
- A. өчүүхнээс ч тансаг сайхныг тодорхойлсон
 - B. ерийнөөс ерийн зүйлийг ч бүлэглэсэн
 - C. томоос эс ширхэгийг ч хүртэл зүйлчилсэн
 - D. агуугаас энгийн зүйлийг багтааж тоочсон
 - E. баруунаас зүүн хүртэлх орон зайг харьцуулсан
7. “ялаа шумуул....., цагаан дэрс....., ээжийн минь мөргөл залбирал ч.....” гэсэнд ямар үгийг хурааж найруулсныг нөхөөрэй.
- A. шаргал говь юм
 - B. цэнхэр тал юм
 - C. эх орон юм
 - D. уртын дуу юм
 - E. алтан ганжир юм
8. Өгүүлбэрээс орон зайн уялдаа холбоог зөв тогтоосон хэсгийг сонгоорой.
- ... сургууль, ээж, багш нараа мөр зэрэгцэн суух бяцхан андаа бас сурах бичиг, суудаг ширээ сандал, ангийнхаа цонх, цонхоор харагдах улиас, улиасны мөчир бүхэн, мөчир дээр нь суух бяцхан болжморыг хүртэл Эх орон гэж ойлгосон*
- A. цонхоор харагдах улиас, мөчир дээр нь суух болжмор
 - B. ангийнхаа цонх, бяцхан болжмор, улиасны мөчир бүхэн
 - D. мөр зэрэгцэн суух бяцхан андаа, сурах бичиг, улиас
 - C. мөр зэрэгцэн суух бяцхан андаа, ширээ сандал, ээж
 - E. цаст Алтай, сүрлэг Хангай, шаргал говь, гоо сайхан
9. Холимог нийлмэл өгүүлбэр дэх “санаж” гэсэн үгийг цагийн утгаар дэлгэрүүлсэн гишүүн өгүүлбэрийг олоорой.
- Итгэл алдрах бүрдээ би Монголын гайхамшигт баатруудыг санаж, тэднээс бэрхийг давах хүч тэнхээ авдаг.*
- A. хүч тэнхээ авдаг
 - B. бэрхийг давах
 - C. итгэл алдрах бүрдээ
 - D. баатруудыг санах
 - E. би тэднээс авдаг



10. Онцолсон өгүүлбэрүүд утгын ямар харьцаанд байна вэ?
Алаг морьтойгоо хүн ардын зүрх сэтгэлд мөнхөрсөн Дандар баатар, Норовбанзадын дуулсан уртын дууны уран нугалаа, өвлийн шөнөөр эмгэн ээжийн ярьсан үлгэр, бударсан цасан дундуур хөтлөлцөн алхах охид хөвгүүд цөм Эх орон юм.
- A. “охид”, “хөвгүүд” гэх үгс нь хүйсээр эсрэг тул эсрэг утга
 B. “өвлийн шөнөөр”, “цасан дунд” гэх үгс нь цаг ба орны утгыг илтгэж байгаа учраас ойролцоо утга
 C. “Норовбанзад”, “эмгэн ээж” гэх үгс нь хүнийг нэрлэж байгаа учраас зүйлчилсэн утга
 D. “дуулсан дуу”, “ярьсан үлгэр” нь өгүүлэх байдлаараа ижил тул ойролцоо утга
 E. “хүн ард”, “зүрх сэтгэл” гэх үгс нь хоршин зэрэгцэж бүтсэн тул ойролцоо утгатай
11. “Явуухулангийн **хайр**, Чойномын **хилэн**” онцолсон үгсээр юуг төлөөлсөн бэ?
 A. уран бүтээлийн онцлог
 B. амьдралын нэгэн агшин
 C. бүтээл туурвисан цаг хугацаа
 D. найрагчдын ялалт, уй гашуу
 E. найрагчдын орон зай
12. “**боргоцой** жаахан үрсийн минь” гэсний онцолсон үгээр ямар шинжийг адилтгасан бэ?
 A. “боргоцой жаахан” гэсэн овор хэмжээ
 B. “хуш модны самрын хонгорцог үр” гэсэн харьяаны шинжээр
 C. “хуш модны самрын хонгорцог үр” гэсэн бүтсэн эд
 D. “бондгор, бундгар үр” гэсэн төсөөтэй шинж
 E. “бондгор, бомбогор үр” гэсэн хэлбэр төрхийн шинж
13. “нугалаа” гэсэн үг эхэд ямар утгаар орсон бэ?
 A. усны тахиралдан мушгирсан эргүүлэг
 B. аливаа зүйлийг эвхэн нугалахад тогтсон ором
 C. дуу хөгжмийн айзам хөгийн чимэг
 D. шүлгийн мөр дэх утгын хэмнэл
 E. хөгжмийн ая хэмнэлийг бууруулах
14. “Сүр жавхлантай 700 гаруй сүм хийд монгол нутаг даяар **сүндэрлэж**” гэсний онцолсон үгийг “босож” хэмээх үгээр соливол найруулгад ямар өөрчлөлт гарах вэ?
 A. хүндэтгэлийн утгатай болно
 B. найруулгын ерийн зэрэгтэй болно
 C. найруулгад өөрчлөлт орохгүй
 D. доод найруулгын зэрэгтэй болно
 E. найруулгын дээд зэрэг хэвээр байна
15. “шанд” хэмээх үгийн утгыг зөв тайлбарласныг олоорой.
 A. борооны дараах урсгал ус
 B. газарт тогтсон их ус
 C. хонхор газарт тогтсон цөөрөм
 D. газраас ундрэн гарах ус
 E. устай нүх буюу худаг
16. “бяцхан **андаа** эх орон гэж ойлгосон цагт л” гэснээс онцолсон үгийн тэг бүтээврийг олоорой.
 A. -ийг B. -ыг C. -ийн D. -ын E. -аас
17. “Бидний оюун санааны амьдрал эхлэх **буюу**” гэснээс онцолсныг соливол аль нь тохирох вэ?
 A. ба B. үгүй C. дээ D. юм E. хийгээд



18. Утгаараа тохирохгүйг сонгоорой.
 *Лувсангийн сэтгэл уйтгарлана.*
 А. Хасаг тэрэг шинэчлэгдэхэд В. Хасаг тэрэг хяхнах тутам
 С. Хасаг тэрэг хяхнах үед D. Модон тэрэг дуугарах цагт
 Е. Хасаг тэрэгний хяхнах тутам
19. “хэцүү, бэрх” гэсэн утгатай хэлцийг үг нөхөж бүтээгээрэй.
Алганы хонхорхой
 А. зуух В. зажлах С. залгих D. таслах Е. хазах
20. Тохирохыг сонгож нөхөөрэй.
Үдэш орой айлын гэрэл харагдах сайхан
Үрээ морины *сайхан*
 А. хөлөө олох В. хөл алдах С. хөл нийлэх
 D. хөл хөнгөрөх Е. хөл газар хүрэхгүй
21. Аль хэсгийн өгүүлбэрт таслал тавих вэ?
 А. Би ахын өгсөн номыг авлаа шүү В. Би номыг авлаа шүү
 С. Би авлаа шүү ахын өгсөн номыг D. Ахын өгсөн номыг би авлаа шүү
 Е. Би авлаа шүү
22. “сур+валж+л+га” гэснийг зөв залган бичсэнийг олоорой.
 А. сурвалжлага В. сурвалжилга С. сурвалжалга
 D. сурвалжил Е. сурвалжилга
23. “Заахын тийн ялгалын “-г” нөхцөлийг хэлний угийн “н” гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгана” гэсэн дүрэмд тохирохыг олоорой.
 А. морийг уургалъя В. далайг туулья С. агшинг дурсъя
 D. самбарыг арчих Е. чимээг сонсох
24. “ор” язгуураас бүгд үг бүтээх дагавартай хэсгийг сонгоорой.
 А. -лт, - лого, - мж, - лоо В. -лт, - лого, - сон, - мж С. -лт, - лого, - мж, -в
 D. -лт, - лого, - мж, - ц Е. -лт, - в, - ын, - лого
25. “Нар шарах нь ээ” гэснээс онцолсон баймж бүтээврийн утгад тохирохыг олоорой.
 А. боломжийг батлах В. онцлох утгатай С. багасган адилтгах
 D. ерөнхийлөн асуух Е. үгүйсгэх утгатай
26. Ж. Саруулбуян “Бодончар богд” өгүүллэгтээ “*Үзүүр нь хэрэмний чих шиг урт шар хялгаастай, жаахан доошлоод бор, улаан, ягаавтар холилдон ууссан үзэмжит урт чихээ хайчлан солбиулна*” гэж өгүүлжээ. Дүрслэлтэй дүйх утгатай /Монголын нууц товчоо/-г сонгоорой.
 А. мөчир бүрээс мөч гуя өлгөв
 В. урагт эс тооцогдох атал энд юу хийж сууна
 С. үхвэл үхье, амьдарвал амьдаръя
 D. хар хур шувууг бор харцага барьж идэхийг үзэв
 Е. гол дайрт, годил сүүлт орогшинхул морио унав
27. Үг сонгож, тодорхойлолтыг гүйцээгээрэй.
 *гэдэг нь харамсах, гашуудах сэтгэлийг маш хурц илэрхийлсэн, хошин шог жүжгийн эсрэг хандлагатай байдаг.*
 А. телевизийн жүжиг В. инээдмийн жүжиг С. драмын жүжиг
 D. эмгэнэлт жүжиг Е. хошин шог жүжиг



35. “Модоо тарья” гэсний онцолсон үгийн тэг бүтээврийг олоорой.

- | | | | | |
|------|------|------|------|------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠮᠣᠳᠤ | ᠮᠣᠳᠤ | ᠮᠣᠳᠤ | ᠮᠣᠳᠤ | ᠮᠣᠳᠤ |

36. “ᠮᠣᠳᠤ ᠲᠠᠷᠢᠶ᠋᠎ᠠ” гэснийг уншаарай.

- | | | |
|-----------------|-----------------|--------------|
| A. эрхний оосор | B. өрхний оосор | C. эргийн ус |
| D. өрөөний утас | E. энгийн оосор | |

37. “ᠮᠣᠳᠤ ᠲᠠᠷᠢᠶ᠋᠎ᠠ” онцолсон үгийг зөв таниарай.

- | | | | | |
|---------|--------|--------|-------|--------|
| A. оюун | B. оюу | C. охь | D. уг | E. огь |
|---------|--------|--------|-------|--------|

38. Зарим гадаад үгэнд орсон “у” үсгийг монгол бичигт “ү”-ээр бичдэг зүй тогтлоор “клуб” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

- | | | | | |
|------|------|------|------|------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠬᠯᠤᠪ | ᠬᠯᠤᠪ | ᠬᠯᠤᠪ | ᠬᠯᠤᠪ | ᠬᠯᠤᠪ |

39. “гийгүүлэгч+эгшиг+гийгүүлэгч”- ээс бүтсэн бүтээврийг сонгоорой.

- | | | | | |
|------------------------------|------------------------------|------------------------------|------------------------------|------------------------------|
| A. | B. | C. | D. | E. |
| ᠭᠢᠶᠢᠭᠦᠯᠡᠭᠴᠢᠨᠭᠡᠭᠰᠢᠭᠢᠭᠢᠭᠦᠯᠡᠭᠴᠢ | ᠭᠢᠶᠢᠭᠦᠯᠡᠭᠴᠢᠨᠭᠡᠭᠰᠢᠭᠢᠭᠢᠭᠦᠯᠡᠭᠴᠢ | ᠭᠢᠶᠢᠭᠦᠯᠡᠭᠴᠢᠨᠭᠡᠭᠰᠢᠭᠢᠭᠢᠭᠦᠯᠡᠭᠴᠢ | ᠭᠢᠶᠢᠭᠦᠯᠡᠭᠴᠢᠨᠭᠡᠭᠰᠢᠭᠢᠭᠢᠭᠦᠯᠡᠭᠴᠢ | ᠭᠢᠶᠢᠭᠦᠯᠡᠭᠴᠢᠨᠭᠡᠭᠰᠢᠭᠢᠭᠢᠭᠦᠯᠡᠭᠴᠢ |

40. Зөв харгалзуулсныг олоорой.

- | | | |
|---------------|---------------|---------------|
| 1. | 2. | 3. |
| ᠮᠣᠳᠤ ᠲᠠᠷᠢᠶ᠋᠎ᠠ | ᠮᠣᠳᠤ ᠲᠠᠷᠢᠶ᠋᠎ᠠ | ᠮᠣᠳᠤ ᠲᠠᠷᠢᠶ᠋᠎ᠠ |

- а. торгоны саа
- ь. сүйх тэрэг
- с. бодож сэтгэ

- | | | |
|---------------|---------------|---------------|
| A. 1a, 2b, 3c | B. 1b,2c, 3a | C. 1b, 2a, 3c |
| D. 1c, 2a, 3b | E. 1c, 2b, 3a | |



ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг будаарай.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр нэг оноотой.

2.1. Уншаад зөв харгалзуулаарай.

a.	b.	c.	d.	e.	1.	2.	3.	4.	5.
ᠠᠭᠠ	ᠠᠭᠠᠨ	ᠠᠭᠠᠨ	ᠠᠭᠠᠨ	ᠠᠭᠠᠨ	ᠠᠭᠠᠨ	ᠠᠭᠠᠨ	ᠠᠭᠠᠨ	ᠠᠭᠠᠨ	ᠠᠭᠠᠨ

2.2. Нэг төрлийн дүрэмд хамаарахыг харгалзуулна уу.

- | | |
|-----------------------|---------------------|
| a. тусалъя, нэхье | 1. гарч, тойрч |
| b. хэвлэ, нарла | 2. хольсон, завьгүй |
| c. нөхцөлөөс, харахад | 3. усал, замчил |
| d. сахиж, барил | 4. нутгийн, тэргээр |
| e. засаж, сонсож | 5. хаая, оёё |

2.3. Онцолсон хэлцийг утгатай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---|----------------------------|
| a. Алга дарам газраас эх орон минь эхэлдэг гэж би боддог. | 1. Үйлийн дүр байдлын утга |
| b. Нүд ирмэхийн төдийд амьдрах насандаа ихийг сурч мэдээрэй. | 2. Шалтгааны утга |
| c. ..Болормаагийн нар гарч уйтгарлахыг мартана. | 3. Зорилгын утга |
| d. Зээр гүйцэмгүй уудам талаар Зуузай холбон давхиж явна. | 4. Цагийн утга |
| e. Тэр ав аянаас хойш Анутай хувь заяагаа холбоно гэж бодлоо | 5. Хэмжээ заасан утга |



2.4. Зохиолын эшлэлийг онцлог шинжтэй нь зөв харгалзуулна уу.

- а. ...Ингээд “сайн морь” гэснээр “**Сайн ноён хан**”, түшсэнээр нь “**Түшээт хан**”, зассанаар нь “**Засагт хан**”, эмээлийг нь авч, идээ будааг нь гаргаж, мэргэн цэцэн ухаан гаргаснаар нь “**Цэцэн хан**” гэсэн цол хүртээсэн байна.
- б. 1976 оны бороо, ногоо тэгш сайхан зун **С.Эрдэнэ тэргүүтэй хэдэн зохиолч** уул даваа, ус гол гаталсан урт зам туулж, **Архангайн Хорго, Тариат** хүрлээ. Шөнө нь бороо орж, өдөр нь нар гарч, цаг агаар тусгай **хөтөлбөртэй** мэт байв.
- с. ...Өрхөө хуруун чинээ газар цоолоод түүгээр туссан нарны гэрэлд тэр цаасаа тавьж, **нэг ширхэг хялгасны үзүүрээр бийр болгоод** бичсэн аж.
- д. Эрт цагт **мянган толгойтой, ганц сүүлтэй нэгэн могой**, бас мянган сүүлтэй, ганц толгойтой бас нэгэн могой хамтад амьдран суувай.
- е. **Бурханбогд** энэ өглөө цагаасаа эрт босов. **Бор дүрхэн тавилгатай** жижигхэн байшин нь зэврүүхэн, харин ширээн дээр элсэн чихэр түрхсэн хоёр зүсэм талх, будаг нь халцарсан халуун савтай цай бэлэн байлаа.
1. Соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх зорилготойгоос гадна уран сэтгэмж оруулан сонирхолтой хэлбэрээр бичсэн тэмдэглэл
2. Амьдралд тохиолдсон, тохиолдсон байж болзошгүй бодит, түүхт үйл явдал, эсвэл ортой явдлаас эх үндэс авч уран сэтгэмжээр баяжуулсан.
3. Үнэн байдлыг үлэмж хэтрүүлж, бие хувилуулан дүрслэх түвшний уран саналгад түшиглэдэг, ер бусын сонин хачин үйл явдалтай.
4. Баатрын амьдрал, үйл хэргийн нэг жижиг хэсэг, учрал тохиолдлыг өгүүлэх ба хүний нийгмийн утга чанартай, анхаарал татсан эгзэгтэй нэг гол асуудлыг хөндсөн байна.
5. Хурц зөрчил, хураангуй өгүүлэмж, үйл явдлын эргэлт, сонин содон үйл явдал, уран тайлалтайгаараа ялгардаг.

